

Когнитив артефакт ба соёлын когнитив хэлбэр

Доржпүрэв Чулуунгэрэл, доктор (Ph.D)
Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн
Бодлого судлалын салбар, Улаанбаатар, Монгол Улс
chuluungereld@mas.ac.mn, <https://orcid.org/0000-0002-7808-3673>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

*артефакт, когнитив
артефакт, соёлын
ментефакт, соёлын схем,
соёлын фрейм, соёлын
сценари, соёлын загвар*

Хураангуй: Хүний сэтгэцэд соёл хэрхэн үүсэж, хөгжсөн асуудал хүн судлаачдын сонирхлыг ихэд татаж, судалгааны явцад онолын хэд хэдэн баримтлал, бүтэц гарч ирж байсан. Улмаар когнитив хүн судлалын хүрээнд соёлын танин мэдэхүйн агуулгыг системтэйгээр авч үзэх оролдлогууд хийгдсэн юм. Үүний үр дүнд соёлын когнитив хэлбэрүүдийг тогтоосон. Мөн танин мэдэхүй нь хүний тархины дотоод үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, харин хүрээлэн буй орчин, нийгэм, соёлын бодит үр дүн, өөрчлөлт хувьсал, технологийн орчинтой нягт уялдаж хөгждөг гэж олон судлаач үздэг. Энэ хүрээнд когнитив артефакт нь хүний сэтгэхүйн процессыг хөгжүүлэх гол механизм болно. Нөгөө талаас когнитив артефакт нь соёлын танин мэдэхүйн хэв шинж, өөрөөр хэлбэл соёлын когнитив хэлбэрүүдийн суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Ийм учраас когнитив артефактын онолын үндэс, түүний соёлын когнитив хэлбэрүүдтэй холбогдох үйл явцыг судлаачдын бүтээлд тулгуурлан авч үзэхийг зорив.

Cognitive artifact and cultural cognitive forms

Chuluungerel Dorjpurev, (Ph.D)

*Department of Policy Studies, Institute of Philosophy, Mongolian Academy of
Sciences, Ulaanbaatar, Mongolia*

chuluungereld@mas.ac.mn, <https://orcid.org/0000-0002-7808-3673>

Keywords

*artifact, cognitive artifact,
cultural mentefact, cultural
frame, cultural schema,
cultural script, cultural
model*

Abstract: The question of how culture emerges and develops within the human mind has long attracted the interest of anthropologists, leading to the formation of various theoretical approaches and conceptual frameworks. Within the field of cognitive anthropology, scholars have attempted to examine the content of cultural cognition in a systematic manner, resulting in the identification of cultural cognitive forms. Many researchers argue that cognition is not limited to the internal processes of the human brain but develops in close interaction with the surrounding environment, society, cultural practices, and technological conditions. In this context, cognitive artifacts function as key mechanisms that shape and enhance human cognitive processes. Moreover, cognitive artifacts constitute the foundational conditions for culturally specific cognitive patterns, or

© The Author(s), 2025



cultural cognitive forms. For these reasons, this study aims to explore the theoretical foundations of cognitive artifacts and examine how they are connected to cultural cognitive forms, drawing upon the works of major scholars in the field.

I.ОРШИЛ: АРТЕФАКТ ГЭХ ОЙЛГОЛТЫН ТУХАЙ

Соёлын когнитив хэлбэрүүдийг судлахад юуны өмнө *соёлын артефакт* гэх ойлголтыг авч үзэх хэрэгтэй байдаг. Артефакт гэдэг бол аливаа анхдагч суурь ойлголт болж буй зүйлийг илэрхийлсэн нэршил юм. Хүн төрөлхтөн үүсэл хөгжил бүхий л идэвхтэй үйлдлийнхээ явцад олон төрлийн артефактуудыг ашиглаж иржээ. Улмаар артефакт нь когнитив шинжтэй болж, бэлгэдэл, хэл, урлаг, яруу найраг зэрэг ухамсрын хэлбэрийг ашиглан, үйлдлийн хүртээмжтэй шинжид шилжсэн байна.

Артефакт нь:

1. Сэтгэл судлал буюу хүн судлал ба санаа бодлын холбоос
2. Бүтцийн илрэх харилцаа хамаарал
3. Герменевтик буюу ойлголтыг текстээр тайлбарлах гэсэн байдлаар тодорхойлогдоно.

Артефактын оршихуйн хэлбэрийг сүүлийн үед дараах байдлаар тодорхойлж байдаг. Үүнд, эдийн соёлын объектын хэлбэр, хамаарлын хэрэглээний өөрчлөлтийн хуваарилалтаар, утга агуулгын ойлголт, санаа бодол, соёл хоорондын хамаарлын үнэт зүйл гэжээ. (Л.Пүрэвхам, 2010)

Америкийн хүн судлаачид соёлын артефакт, соёлын когнитив хэлбэрийн асуудлыг судлахдаа хүний хэрэгцээ, бодит байдлын үр дүн, когнитив ачаалал, цэвэр биологийн хүртээмжит байдал зэрэг ойлголтуудыг дэвшүүлсэн. Америкийн хүн судлаач, философич М.Вартофский артефакт нь 3 янз байна хэмээн тодорхойлсон. Үүнд:

1. Артефакт нь материаллаг зүйлс, үзэл санааны зүйлийн тухай бидний төсөөлөл, арга юм
2. Артефакт нь загвар, зан заншил, норм хэм хэмжээ, хууль, таамаглал байж болно
3. Артефакт нь гадаад ертөнцтэй холбогдохгүй үйлдлээр илэрхийлэгдэж болно. Гэхдээ артефактын хөгжлийн зүй тогтол нь хэрэгцээнд чиглэсэн байна (Marx, 1979) гэжээ.

М.Вартофскийн тодорхойлсон материаллаг ба үзэл санааны артефакт гэдэг нь нэг талаас артефактын материаллаг хэлбэр нөгөө талаас артефактын дам төсөөлөл болж, артефактын шинж чанараа тодорхойлж байдаг юм. Материаллаг хэлбэрийн артефактын шинж чанараар материаллаг соёлын үүслийг тодруулж болно. Уламжлал, зан заншил, норм хэм хэмжээтэй цуг хүний практик үйл ажиллагааны чадвар, арга бүрэлдэж эзэмшигдэж байдаг. Энэ үед хүний үйл ажиллагааны өөрчлөлттэй зэрэгцэн, артефактын шинжид хувьсал гарч, аливаа хөгжлийн урьдчилсан нөхцөл нь болох тохиолдол гарна.

Америкийн судлаач М.Коул артефактыг хүн төрөлхтний түүхийн материаллаг болон оюун санааны бүтээгдэхүүн гэж үзсэн. М.Коул “Хувь хүний соёл, зан төлөвийн нөлөөгөөр илэрч байгаа бүх зүйл артефакт юм. Соёл бол артефактуудын нэгдэл бөгөөд хүний зорилго чиглэлтэй үйл ажиллагаа, ертөнцийг бүтээгч тэмүүлэл артефакт болно” (М.Коул, 1997) гэжээ. Хүний үйл ажиллагааны өөрчлөлт, нийгмийн хөгжил дэвшил артефактыг хэрхэн ойлгож болох үзэл санааны зүйл болгож байдаг. М.Коул артефактыг анхдагч ба хоёрдогч гэж ангилсан. *Анхдагч*

артефактыг хүний материаллаг хэрэгцээний багаж зэмсэг, үлгэр домгийн дүр төрх, бичвэр ба харилцааны сүлжээ юм гэжээ. *Хоёрдогч артефакт* нь соёлын загвар, соёлын когнитив хэлбэрүүд, соёлын арга байх юм хэмээн онцолсон байна. Хүн хоёрдогч артефактуудын тусламжтайгаар ойлголт, сэтгэлгээгээ баяжуулж, туршлага хуримтлуулан, материаллаг ба оюун санааны соёлыг бүтээдэг ажээ.

Ингэхлээр артефакт гэдэг ойлголт өргөн утга агуулгатай бөгөөд онол сургаалын түвшинд дараах нөхцөлүүдээр тайлбарлагдаж байна. М.Коулын артефактын тухай сургаал нь соёлын суурь ойлголт, материаллаг ба үзэл санааны шинжийн нэгдэл, соёлын загваруудын нэгдэл, соёлын когнитив хэлбэрүүдийн холбоо, соёлын тусгай орчин, субъект объектын харилцаа, субъект объектын харилцаа, үйл ажиллагаатай холбоотойгоор тайлбарлагдаж байна.

Харин судлаач Г.Симон артефактыг нэг талаас хүн орчиндоо дасан зохицох нөхцөл, нөгөө талаас бэлгэ тэмдгийн систем гэж үзжээ. Тэрээр артефакт, байгалийн үзэгдлээс ялгаатай байх шинжийг тодорхойлох оролдлого хийсэн. Г.Симоны дэвшүүлснээр “Артефакт нь ямагт хүний хөгжил, үйлдлийн үр дагавар, шалтгаан нь болдог. Мөн артефакт бодит байдал дээр байдаггүй үзэгдэл юмсын дуурайлалд илэрдэг. Артефакт нь үүрэг, зорилго, дасан зохицох механизмуудыг агуулж байдаг онцлогтой” (С.Тайлор, 1987) ажээ.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Уг өгүүлэлдээ түүхэн ба логик шинжилгээ, харьцуулсан арга зүй, танин мэдэхүйн аргыг ашигласан.

III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгааны явцад М.Коулын онол, Д.Норманы когнитив аргын үзэл баримтлалыг харьцуулсан сонирхолтой ойлголт бий болсон. Тэд “Когнитив

артефакт” гэсэн өгүүллээрээ харьцуулсан дүгнэлтээ илэрхийлж, түүх, соёл, сэтгэл судлал ба когнитив шинжлэх ухааны зарчмын ялгааг гаргажээ.

М.Коул когнитив артефактыг *сэтгэл когници* гэж үзэж байхад Д.Норман сэтгэлгээг хүний өөрийнх нь үйлдэл юм гэж үзээд, артефактыг сэтгэлгээ рүү хандсан гадаад зүйл болно гэж тодорхойлсон (D.A.Norman, 1991). Ингэхлээр Норманы дэвшүүлснээр артефакт нь ухамсрыг бүтцэд оруулахгүй, зөвхөн ухамсарт нөлөөлж чадна гэсэн ойлголт болжээ. Гэвч соёл, түүх, сэтгэл судлаачид соёлын артефактыг сэтгэлгээний хэлээр бүтэц, суурь гэж үзсэн байна.

Соёлын когнитив артефактын ойлголтын зэрэгцээ “соёлын ментефакт” гэх ойлголтыг Оросын эрдэмтэн В.В.Красных соёл судлалын ухаанд оруулж ирсэн. Түүний үзсэнээр, *ментефакт нь мэдлэг, үзэл баримтлал, төсөөллийн шинжээрээ ялгаатай*. Мэдлэг нь агуулгын нэгжийг өөртөө багтааж, бүтэц болон шаталсан системүүдийн цогц болж байдаг. Төсөөлөл бол өөрийн гэсэн дүр зургийг агуулахаас гадна үнэлэмжтэй холбоотой. Төсөөлөлд сүнс, артефакт гэсэн ойлголтууд ч багтана. В.Красных *“артефактыг домгийн төсөөлөлтэй холбож, зарим нэгэн материаллаг зүйлсийг артефакт гэнэ”* (В.В.Красных, 2003) гэжээ. Ментефакт нь мэдлэг үзэл баримтлал, төсөөлөл дээр ялгагдаж байдаг. Үл үзэгдэгч малгай, хурдан гүйгч гутал, нисдэг хивс гэх мэт зүйлийг нэрлэж болно. Түүний энэ ойлголт нь мэдлэг гэхээс илүү нэмэгдэл утга бүхий төсөөлөл гэж ойлгогддог.

Орчин үед когнитив ухааны категорийн аппаратаас эхлээд хиймэл оюун ухаан, когнитив сэтгэл судлал, когнитив хэл шинжлэл, когнитив соёл судлалын хүрээнд когнитив хэлбэрийн асуудлууд чухал байр суурьтайгаар оролцож, үзэгдэл юмсын тайлбарлалыг илүү ойлгомжтой болгох нөхцөл бүрдэж

байна. Ийм хэлбэрүүд нь *когнитив схем, фрейм, загвар, сценари* юм.

Схем буюу бүдүүвч хэмээх нэр томъёог анх Английн сэтгэл судлаач Ф.Бартлет “Ой тогтоолт” хэмээх өөрийнхөө номонд хэрэглэжээ (F.Bartlett, 1932). Гэхдээ Ф.Бартлет энэ нэрийг дээд мэдрэлийн тогтолцоог судлаач Г.Хидээс авсан. Г.Хид нь хүний ухамсарт төсөөлөл хэрхэн бүрэлдэж байгааг тайлбарлахдаа энэхүү томъёоллыг ашиглажээ. Дараа нь 1922 онд Кембрижийн сэтгэл судлалын лабораторид ой тогтоолтын механизмын туршилт хийж, хүмүүсийн өнгөрсөн үеийн түүх дурсамжийг судалсан байна. Ихэнх тохиолдолд хүмүүс өнгөрсөн үеийн туршлагаа ярьж, амаар дамжуулахдаа бодит байдлын тогтсон төсөөлөл рүү хандаж байгаа нь ажиглагдсан. Хожим ингэж олон давтагдаж буй төсөөллийг “Бартлетын схем” гэж нэрлэсэн байна. Ф.Бартлетын дараа “бүдүүвч” гэх нэр ойлголтыг Скемп, Олдфильд, Зангвилл, Румельхарт нар идэвхтэй хэрэглэж улам боловсронгуй болгосон.

Когнитив бүдүүвчийн олон хувилбар гарч ирсэн. Ерөнхий утгаараа бүдүүвч нь хөгжлийн тухай боломжит таамаглал, харилцаа, объект субъектын харилцаанд дахь нэгдмэл төсөөлөл, хувь хүний туршлага, үнэлэмж болсон төсөөлөл зэргийг агуулна. Б.М.Величковский “Бүдүүвч бол харьцангуй тогтвортой. Туршлагын үйлдэл, бүтцийг нэгтгэж, аливаа хөгжлийн зүй тогтол, агуулга, дотоод холбоог нь илэрхийлсэн объектын төрлүүд ба хүрээлэн буй орчны өөрчлөлтийг тусгасан төсөөлөл мөн” (Б.Т.Величковский, 2006) гэжээ. Бүдүүвчийн тусламжтайгаар хүн хамгийн оновчтой үйл ажиллагааг бий болгох нэмэлт нөөцийг олж авдаг. Иймээс бүдүүвч бол үйл ажиллагааны зайлшгүй чухал хэсэг бөгөөд хүний өдөр тутмын үйлдэл, туршлага, нөхцөл, объектэд чиглэсэн харилцаа нь ухамсартай ба ухамсаргүйн түвшинд өрнөнө. Үүнийг когнитив аппаратын үүднээс авч үзвэл түүнд хүний өнгөрсөн

туршлагыг илтгэх бүдүүвчүүд оршдог гэж үздэг. Энэхүү бүдүүвчийн ачаар хүнд аливаа үйл явдал, хөгжлийн логик харагдах бололцоотой. Мөн хүний ахуйн тогтвортой нөхцөл байдал, түүнийг хэрхэн хангах тухай дүгнэлт хийх бололцоо ч олдоно. Ямар ч үед аливаа шийдвэрийг хурдан гаргах эсвэл мэдээллийн нөөц дутагдах тохиолдол гардаг. Энэ үед бүдүүвч нь объектыг хурдан таньж мэдэх боломжтой. Бүдүүвчийн гол үүрэг нь өмнөх туршлагыг зохион байгуулах, ижил төст мэдээллийн үйл ажиллагааг удирдах явдал бөгөөд энэ үйл ажиллагаа нь ойлголт, категори, төлөвлөлтийн оролцоотойгоор шийдэгддэг юм. Мөн бүдүүвч нь идэвхтэй үйл явц болж чаддаг. Бүдүүвчийг тодорхойлох, ангилах оролдлогууд өнөөг хүртэл хийгдсээр байна. Жишээ нь, Ж.Ф.Ришар бүдүүвчийн хэд хэдэн шинжийг тодорхойлсон. Үүнд:

1. Бүдүүвч бол ой тогтоолтоор байнга сэргээгдэж байдаг
2. Бүдүүвч бол автономит биеэ даасан шинжтэй төсөөлөл, мэдлэг юм
3. Бүдүүвч нь тоон хамааралтай ерөнхий ба хийсвэр бүтэц бөгөөд декларатив мэдлэгийн илэрхийлэл мөн (Ж.Ф.Ришар, 1998) гэжээ.

Ж.Ф.Ришараас гадна Д.Румельхарт “Бүдүүвчийг хийсвэрлэлийн бүх түвшний мэдлэгт хамаатай, нэгээс нөгөө рүү шилжих онцлогтой, завсарлагаатай, мэдлэгийг илүү буулгаж чаддаг, танин мэдэхүйн багаж зэвсэг болсон идэвхтэй үйл явц” (D.E.Rumelhart, 1980) гэж тодорхойлжээ.

Гэвч бидэнд бүдүүвчийн тухай ерөнхий тодорхойлолт, шинжээс гадна когнитив бүдүүвчид хамааралтай шинж байдлуудыг авч үзэх шаардлага гарч байна. Ихэнх судлаачид бүдүүвчийг нэг нь нөгөөдөө захирагдсан зохион байгуулалт болгож харуулдаг. Гэхдээ бүдүүвч нь объект руу чиглэсэн үйлдэл, эргэцүүлэл хийх үед идэвхжиж,

хүртээмжтэй болж, ашиглалтын давтамж нь шинэчлэгддэг онцлогтой. Мөн бүдүүвч нь ойлгогдож байгаа сэдлийг тайлбарлаж, субъектын анхаарлыг аль ч төрлийн мэдээлэл рүү чиглүүлж чаддаг.

Когнитив бүдүүвч нь өөртөө тодорхой тооны элементүүдийг агуулахаас гадна нийлмэл бүтэцтэй, тодорхой дэс дараалалд өрнөдөг. Харилцааны үед хүний туршлагаас хамаарч, ой тогтоолтод дараагийн үйлдэл хийх нөхцөлийг бүрдүүлж байдаг онцлогтой. Энэ нь зогсонги царцанги зүйл огт биш, харин ч мэдлэгийн урьдчилсан өгөгдөл болсоор ирсэн динамик үзэгдэл юм. Бүдүүвч нь дараалалд өрнөж байдгаараа хатуу тогтоосон зохион байгуулалттай мэт боловч шугаман зохион байгуулалт, чөлөөт бүдүүвч, өөрийн бүдүүвч зэрэг онцлогуудыг гаргаж чаддаг.

“Когнитив бүдүүвч нь универсаль бүдүүвч, хувь хүний соёлын бүдүүвч гэж хоёр ангилагддаг. Универсаль бүдүүвч нь бүх хүнд байна. Схем нь тусгай хувь хүнд байна. Харин соёл нь тодорхой нийгэмлэгийн гишүүнчлэлд хуваагдаж оршино” (R.W.Casson, 1981).

Р.Андрад бичихдээ, “Схемийн когници нь соёл ба сэтгэл судлалыг холбож байгаа шууд арга зам юм. Бүдүүвч нь сэтгэл судлалын ихэнх үйл ажиллагаанд их, бага хэмжээгээр шууд нөлөөлж байгаа соёлыг сэтгэл судлалын бусад үйл явцтай холбох арга” (D'Andrade, 1994) гэжээ. Андрадагийн энэхүү баталгаа нь соёлын когнитив онол үүсэх түлхүүр болж өгсөн байна.

Харин сэтгэл судлалд бүдүүвчийн дараах хэв маягуудыг ангилж авч үздэг. Үүнд: бие хүний бүдүүвч, үүрэг ролийн бүдүүвч, скриптүүд, чөлөөт агуулгатай бүдүүвч, өөрийн бүдүүвч зэргийг оруулсан. Үүнд:

1. **Бие хүний бүдүүвч** нь тодорхой мэдлэгийн хувьчилсан бүтэц ба тэдгээрийн онцлогийг өөртөө агуулахаас гадна бие хүний голлох

шинжүүд, ялангуяа типологид хамаарах шинж тусгагддаг.

2. **Үүрэг ролийн бүдүүвч** нь нийгмийн тодорхой үүрэгт чиглэсэн шаардлагуудын тухай мэдлэгийг хамааруулж үздэг.
3. **Скрипт буюу үйлдлийн бүдүүвч** нь тодорхой үйл явдлын тухай мэдлэгийн бүтэц бөгөөд энэ нь хүнд боломжит зан төлөвийн зарим нэгэн загварыг санал болгосноор буюу тодорхой нөхцөлд анхаарах боломжуудыг олгодог.
4. **Чөлөөт агуулгатай бүдүүвч** нь мэдээлэл боловсруулах зүй тогтлын хязгаартай цуглуулга ба энэ нь тухайн нөхцөл байдалд шийдвэр гаргахад тусална. Гэхдээ амьдралын туршлага дахь аналог биш юм.
5. **Өөрийн бүдүүвч** нь хүмүүсийн өөрөө өөрийнхөө тухай төсөөллийн аспектыг агуулдаг бөгөөд заримдаа өөрийгөө бусадтай сөргөлдүүлсэн илэрхийлэл болдог. Харин соёл нь хүний бүдүүвчийн хамгийн чухал эх сурвалж болно.
6. **Соёлын бүдүүвч** нь нийгмийн гишүүдэд хамааралтай ба когнитив соёл судлаачдын тусламжтайгаар когнитив схемийг соёлын өнцгөөс харах боломж бүрдсэн гэж үздэг.

Олон судлаачид хувь хүний соёл, туршлагыг когнитив бүдүүвчийн үндэс учраас бүдүүвчийн бүтэц нь соёл гэж үзэн, нийгмийн туршлагуудын нэгдэл бол соёлын бүдүүвч болно гэжээ. Когнитив аппаратад соёлын бүдүүвчийг багтаан оруулах нь нийгэмших ба соёлжих үйл явцын өрнөлттэй холбоотой. Мөн тухайн соёлыг тээгчдээс бас хамаарна. Ихэнх тохиолдолд соёлыг тээгчдэд соёл нь ухамсаргүй байдлаар оршиж байдаг. Хүн соёлын үзэгдлийн идэвхтэй субъект бөгөөд өөртөө тохирсон загварыг сонгох, шинэ мэдээллийг хүлээж авах, эргэцүүлэх, боловсруулах чадвартай. Бүдүүвч өөрчлөгддөг учраас энэхүү өөрчлөлт нь түүхэн үйл явц ба соёлын үзэгдлээр л тодорхойлогддог.

Өнөө үед когнитив үйл явцыг боловсруулж, соёлын когнитив шинжийг тодорхойлохдоо *“фрейм”* гэх ойлголтыг өргөнөөр хэрэглэж байна. Фреймийн гол зорилго нь хэд хэдэн шинжлэх ухааны бүтцэд тухайн мэдээллийг нэгтгэн авч үзэхэд оршиж байна. Улмаар фрейм нь хиймэл оюун ухаан, сэтгэл судлал, социологи, хэл шинжлэл, соёл судлалын ухаанд түлхүү хэрэглэгдэж байгаа юм. Фреймийн тухай судалгаа мөн л олон янзаар хийгдэж, онол сургаал улам л боловсронгуй болж байна.

Америкийн эрдэмтэн, хиймэл оюун ухааны салбарын мэргэжилтэн М.Минский фреймийн онолыг үндэслэгч юм. Тэрээр фреймийг *“тогтонги нөхцөл байдлыг бий болгоход зориулагдсан өгөгдлийн бүтэц”* гэж тодорхойлсон. Мөн фрейм бол объектын тухай мэдлэг бөгөөд түүний онолоор бодит байдлын тухай ойлголт нь фреймийн ой тогтоолтод байгаа харьцуулалттай холбогдож, дамжиж байдаг. Ер нь бодит байдал, фреймийн ой тогтоолтод байгаа мэдээллийн аль аль нь үзэл баримтлалын объекттай ба ертөнцөөс хүлээж авч байгаа мэдээлэлтэйгээ холбоотой. Хүн шинэ гэж үзсэн эд зүйлсийг өөрөөр харах, эсвэл өөрийнхөө ой тогтоолт догроос зарим нэгэн бүтцийг шинээр сонгож харахыг фрейм гэж нэрлэдэг. Фрейм нь өөрчлөгдөх замаар үзэгдэл, үйл явцыг фреймд ойлгогдох ашигтай нөхцөл болдог. Ингэхлээр фрейм нь тогтонги нөхцөл байдлыг төсөөлөхөд зориулагдсан өгөгдөл юм. Хэдийгээр М.Минский фрейм гэх нэр томъёоны зохиогч гэж тооцогддог ч энэ нэрийг этнологийн хэлэнд Э.Гоффман түүнээс өмнө ашиглаж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Э.Гоффман *“фреймийг нийгмийн чухал асуудлыг танин мэдэх аргад хэрэглэгдэх зүйл”* (E.Goffman, 1974) гэж үзсэн. Үүнээс гадна фреймийг когнитив загвар, когнитив схем, когнитив сценари гэх ойлголтуудыг

илэрхийлэх ерөнхий шинж болгон ашигладаг.

Фрейм бол олон нэр томъёоллоос бүрдэж байгаа мэдлэгийн декларатив арга билээ. М.Минский өөрийнхөө онолдоо фреймийг мэдлэгийн бүтэц хэмээн хэрэглэж, хүний сэтгэлгээний үүргийг тодорхойлох, хиймэл оюун ухааныг загварчлах мэдлэгтэй адилтган ойлгосон байсан. М.Минский хүний сэтгэлгээг *“боддог машины”* зарчмаар ажилладаг гэж үзсэн.

Когнитив хэл шинжлэлийн өөр нэгэн сонгодог зохиолч Ж.Лакофф *“Пропорциональ мэдээллийг кодчлох арга бүхий сүлжээний бүтцийг хэлнэ”* (Дж.Лакофф, 2004). Фреймд нийтлэгээр илэрч хуулбарлагдаж буй соёл бас тусна. Когнитив ухаанд фреймийг магадлалын мэдлэгт тулгуурласан, тухайн нөхцөл байдлын түгээмэл шинжийг илэрхийлсэн когнитив бүтэц гэж ойлгодог. Фрейм нь сүлжмэл хэлбэртэй, дундаа зангилаа холбоостой байна. Зангилаа бүхэнд өгөгдсөн даалгавар бий. Зангилаа нь нөхцөл байдлыг тодорхойлох үүрэгтэй. Фрейм терминал ба терминал бус зангилаануудыг бүтэцдээ багтаах бөгөөд эдгээр нь фреймийг илэрхийлж байгаа мэдээлэл баримтуудыг агуулна. Терминал гэдэг бол өөрийнхөө даалгаврыг гүйцэтгэж чадаагүй зангилааг хэлнэ. Терминал нь өөрийнхөө судлах зүйл, тусгай шинж чанаруудыг төсөөлөх боломж олгодог. Мөн объектуудын дунд байгаа харилцаа, мэдээлэл зэрэгт фреймийг ашиглах арга, үйлдлийн тухай мэдээллийг өгнө. Тохирсон мэдээллийг сонгож авах нь өгөгдсөн даалгаврыг оновчтой гүйцэтгэх боломж олгоно. Үүний тулд суурь фреймийн сонголтыг урьдчилсан таамаглал, бэлгэ зөнг ашиглан хийж, удирдлагыг зөв шилжүүлэх, фреймийн соёл, сэтгэлгээний артефактаар голлох мэдээлэл мэдлэгийг фреймд төвлөрүүлэх хэрэгтэй. Фреймийн зөв сонголтоор хүний туршлага зохион байгуулагдана. Тухайн нөхцөл байдал системчлэгдэнэ. Нийгэм, соёлын харилцан үйлчлэлийн

явц дахь хүмүүсийн зан төлөвийг ойлгох боломж тус тус бүрдэнэ.

Оросын хэлний соёл судлалын эрдэмтэд “соёлын шинж бүхий фрейм” гэх нэр томъёог ашигладаг. В.В.Красных хэлэхдээ, “соёлын шинж бүхий фрейм гэх концепт нь коннотаци нэмэлт утга бүхий визуаль дүр төрхийг хамгийн боломжтой гэсэн үзэл баримтлалтай холбодог” гэжээ.

Когнитив сценари гэдэг бол когнитив схем, фреймийн янз бүрийн төрлийг өөртөө агуулсан бүтэц юм. Иймээс фрейм-сценари гэсэн ойлголт үүсчээ. Ялангуяа М.Минский фреймийн онолын үндсэн ойлголтуудын нэгийг фрейм-сценари гэж үзсэн. **Фрейм-сценари гэдэг нь текстийг тайлбарлах үйл явцад боловсрогдож байдаг түлхүүр үг, гол санаа, бүтцийг хэлнэ.** Мөн ой тогтоолтоос урган гарч байгаа текстийн тайлбарлалыг ч хэлнэ.

Когнитив сценарийн онолд зохих хувь нэмрээ оруулсан хүмүүс нь Р.Шенк, Р.Абельсон нар бөгөөд тэд сценарийг когнитив бүтэцтэй гэж үзээд аливаа контекстэд байгаа үйл явдал, дэс дарааллыг илэрхийлэгч гэжээ. Үйл явдалд өгөгдсөн дэс дараалал нь учир шалтгааны зарчмаар тогтсон байдаг. Иймээс үйлдэл бүрийн үр дүн нь дараагийн үйлдэл болох нөхцөл болно. Сценари нь тодорхой дүрийг санал болгоно. Үүнийг тухайн сценарийн гүйцэтгэгч гэж нэрлэнэ. Сценарийн зохион байгуулалт нь үйл явдлын жагсаалт болдог. Энэ нь зорилго, утга агуулга бүхий нэгдмэл холбоосын удирдлага билээ. Үйл явдлыг ойлгох үед субъектын ой тогтоолтоод байгаа үйл явдалтай тохирч, сценари идэвхжинэ. Ер нь сценари нь тогтсон орчинтой, үүсмэл нөхцөл байдалд хүний зан авир, тухайн үйлдэл хэрхэн өрнөхийг ч илэрхийлж чаддаг ойлголт юм. Сценарийг тодорхойлохдоо Р.Шенк, Р.Абельсон нар **төлөвлөгөө, зорилго, сэдэв** гэх мэт ойлголтуудыг ашиглан урьдчилан тохиролцоогүй нөхцөлд хүмүүсийн зорилго ямар байж болох тухай

таамаглалыг дэвшүүлсэн (R.P.Abelson, 1977). Улмаар сценари шинээр бүрэлдэх бөгөөд энэ үйл явц нь өнгөрсөн үеийн туршлага, олон удаагийн үйлдлээр бий болно. Гэвч өдөр тутмын үйл явдлын дэс дараалал зөрчигдөх явдал гарна. Энэ зөрчлөөс гажилт, саад алдаа гарч, нэг сценариас нөгөөд шилжих дэс дараалал алдагдан, тухайн үйлдлийн сценари байхгүй болно.

Когнитив соёл судлалд **соёлын сценари** гэх ойлголтыг Р.Андрад, М.Коул, К.Нельсон нар идэвхтэй ашигласан. Соёлын сценари нь олон талт шинжтэй. Сценари бол мэдлэгийн зохион байгуулалттай бүтэц юм. Тэр мэдлэгт нь зайлшгүй болон зайлшгүй бус хэсгүүд байдаг. Үүнийг сценарийн когнитив бүдүүвчээр тайлбарладаг. Ингэхээр сценарийн онцлог нь үйлдлийн суурь элементийг агуулж, орон зай, цаг хугацаанд тусгай тусгай үйлдлийг шалтгаант холбоосоор илэрхийлж байдагт оршино. Соёлын сценарийн эх сурвалж нь хувь хүн, хамт олны өөрчлөлт, хүний туршлага юм. Иймээс **сценарийг соёлын уламжлалын түвшинд бий болж буй нийгэм, соёлын мэдээлэл** гэж үзэж болно. Энэхүү мэдээллээс эргээд бүхий л түвшний соёлын уламжлал үүсдэг. Ингэхлээр сценарийг мэдэж эзэмшинэ гэдэг нь соёлыг эзэмшинэ гэсэн үг билээ. Жишээ нь, хүүхэд соёлтой танилцаж, соёлд оролцох нь соёлын сценарийг эзэмших үйл явц эхэлснийг илэрхийлж байгаа явдал юм. Хүүхэд, эцэг эхийн харилцаа, насанд хүрэгчдийн харилцаа, үе чацуутны харилцааны явцад соёлын сценари бүтээгддэг. Заримдаа хүүхдүүдийн үйлдлийг хязгаарлах замаар сценари ч бий болох тохиолдол бий.

Соёлжих үйл явцын дунд сценарийн олонлогийг эзэмших, хувь хүний соёлын чадвар бүрэлдэж байдаг. Энэхүү чадвараас **соёлын загвар** гэсэн ойлголт төрдөг. Соёлын загвар нь олон нийтийн болон тусгай субъектуудын онцлогоор төрөн гардаг. Ямар ч соёлын

загварын үндсэн үүрэг нь соёлын үзэгдлийг утга агуулгатай болгож, когнитив чиглэлээр соёлыг тодорхойлох нөхцөлийг бүрдүүлдэг. Гэхдээ соёлын нөхцөл байдал, субъектын бололцоогоор хязгаарлагдахгүй. Харин ч субъектээс ертөнцтэй харилцах туршлагыг бий болгож, когнитив загварын үндэс суурь нь болно.

IV. ДҮГНЭЛТ

Орчин үед когнитив ухааны категорийн аппаратаас эхлээд хиймэл оюун ухаан, когнитив сэтгэл судлал, когнитив хэл шинжлэл, когнитив соёл судлалын хүрээнд когнитив хэлбэрийн дээрх асуудлууд чухал байр суурьтайгаар оролцож, үзэгдэл юмсын тайлбарлалыг илүү ойлгомжтой болгоход нөлөөлж байна. Тиймээс *когнитив схем, фрейм, загвар, сценари* гэх хэлбэрүүдийг соёлын когнитив шинжийн үүднээс тайлбарлахад түлхүү хэрэглэж байна.

Соёл судлаачид болон түүхчид, сэтгэл судлаачдын судалгаагаар когнитив артефакт нь зөвхөн оюун ухаанд оршоод зогсохгүй нийгмийн харилцааны салшгүй хэсэг болж, практик үйл ажиллагаанд үргэлж оролцож байдаг гэж үзсэн байна. Үүнтэй адилаар хүний оюун ухаанд ч бас фреймүүдийн асар их цуглуулга оршиж байдаг бөгөөд тэдний тусламжтайгаар хүн танин мэдэхүй, ойлгохуй, эргэцүүлэхүй зэрэг янз бүрийн когнитив үйлдлүүдийг хийдэг. Харин когнитив үйлдлүүд хоорондоо тохирохгүй байвал тухайн нөхцөл байдалд тохирсон фреймийг олох үйлдэл зайлшгүй хийгдэнэ. Өөрөөр хэлбэл, фрейм нь аливаа зүйлийн утга санааг бүтээхэд зориулсан сэтгэлгээний сууриас бүрддэг учраас фрейм нь бидэнд нийгэм, соёлын харилцан үйлчлэлийн явцад бусад хүмүүсийн зан төлөвийн илэрхийллийг ижил төст байдлаар ойлгох боломжийг олгодгоороо онцлог юм.

Когнитив артефакт нь хүний танин мэдэхүйн үйл ажиллагаанд

нөлөөлөхөөс гадна соёлын когнитив хэлбэрүүдийн суурь нөхцөл болж, тухайн соёлд түгээмэл ажиглагдах анхаарал, ангилал, хэв шинжийг бүтээдэг. Харин соёл нь өөрийн танин мэдэхүйн хэрэгцээнд нийцүүлэн шинэ артефакт бүтээж, танин мэдэхүй – соёл – артефакт гэх гурвалсан харилцаанд оршиж, өөрчлөгдөж шинэчлэгддэг. Өөрөөр хэлбэл, хүн - артефакт – соёлын орчин гэсэн гурвалсан системийн үйл ажиллагаа юм. Иймд когнитив артефакт ба соёлын когнитив хэлбэрүүдийн судалгаа нь танин мэдэхүйг дан ганц биологийн процесс бус, харин соёлын материаллаг орчинд үүсдэг динамик систем болохыг харуулдаг бөгөөд цаашдын судалгаанд соёлын онцлог, технологийн өөрчлөлт, дижитал орчны нөлөөг хамтатган судлах өргөн боломж нээлттэй байна.

Ашигласан материал

- Wartofsky M. Models, Representation, and the Scientific understanding of culture. Dordrecht: Holland/Boston, USA / L., England D. Reidel. Publishing company. 1979. p.205-206
- D'Andrade Roy.G. Cognitive anthropology in New direction in Psychological anthropology. Cambridge university press. 1994. p.57
- Л.Пүрэвхам Артефакт. УБ.2010.61-р тал
- М.Коул. Культурно-историческая психология. М.1997.стр.141-142
- Taylor C. Interpretation and Science of man. Berkeley university. California press. 1987.p.53
- Simon H. Sciences of the artificial. Cambridge. MIT press.
- Философийн шинэ нэвтэрхий толь. УБ., 2023, -тал
- Norman D.A. cognitive artifacts . In J.M.Carroll designing interaction Psychology at the human-computer interface New-York., Cambridge university press. 1991р.17-20
- Лурия С. Культурные константы, обобщенный сценарий и функционирование социокультурных

- систем. [http://sulourie narod ru / cultconst.htm](http://sulourie.narod.ru/cultconst.htm).
- В.В.Красных Свой среди “чужих” миф или реальность? М.,2003.стр.33
- Schank R.C.and Abelson R.P. Scripts, plans, coals and understanding. N.J.1977.p.248
- Goffman E. Frame analysis. An esay on the organization of experiance. N.Y.1974.p.156
- Casson R.w.language, culture and cognition anthropological perspectives. N.Y.1981.p.20
- Rumelhart D.E. Schema the building blocks of cognition. N.J.1980.p.40-41
- Bartlett F. Remembering. Cambridge England. 1932. P.136
- Д.Чулуунгэрэл Когнитив соёл судлалын үндэс. УБ.2013.